

“ХҮНС ХАНГАМЖ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Хүнс Хангамж төв” ОНӨААТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 206 дугаар тогтоолоор байгуулагдан. Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчийн 45 цэцэрлэг, СХД-ийн нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны хүн эмнэлэг, 74, 121 дүгээр сургуулийн дотуур байрны захиалгын дагуу эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр ханган ажиллаж байна.

Тус газрын дүрмийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Байршил: Сонгинохайрхан дүүргийн 2 дүгээр хороо, хуучнаар “Буянт манал” ӨЭМТ-ийн хуучин өөрийн байр. Одоогоор 18 дугаар хороо, “Авто тээвэр-5” ХК-ны байранд түрээсээр байрлаж байна.

Удирдлага: Б.Ичинхорол нь Нийслэлийн Засаг даргын 2017 оны Б/64 дүгээр захирамжаар захирлаар томилогдон ажиллаж байна.

Бүтэц орон тоо: Батлагдсан орон тоо 20, 2017 онд 20 ажилтантайгаар ажилласан байна.

Бодлогын зорилтын хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, ил тод байдлыг хангаж, мөнгөн хөрөнгө болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох зорилгоор 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна.

Засгийн газрын тогтоол шийдвэр, тушаал, албан даалгавар үүргийн хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоол, 2014 оны 157 тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцүүлэн өөрийн байгууллагын дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг боловсруулан

байгууллагын удирдлагаар батлуулж, мэргэжлийн боловсон хүчин бүхий дотоод хяналтын ажилтныг томилон ажиллуулж байна. Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн тайлан гаргаж ажиллаж байна.

Засгийн газрын “11-11” төв, Нийслэлийн “Call Center”, иргэдийн гаргасан өргөдөл хүсэлтийг шуурхай барагдуулах үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан “Цахим өргөдөл гомдлын программ”, байгууллагын өргөдөл гомдлын Smartcity.mn цахим системд холбогдон ажилчдын нэрсийг шинэчлэн, бүтцийн өөрчлөлтийг шинэчлэн бүртгэж, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэж ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/564 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн цахим архив” төслийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтөөс үүсч буй цахим баримтаар байгууллагын архивын сан бүрдүүлэх улмаар төрийн архивын нэгдсэн сан байгуулж, тоон гарын үсгээр баталгаажсан цахим баримт бичгийн солилцоог нийслэлийн хэмжээнд нэвтрүүлэх иргэд үйлчлүүлэгчид лавлагаа мэдээллийг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэх “Төрийн архивын нэгдсэн систем”-ийг нэвтрүүлэн хэрэгжүүлж ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/252 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн журам”-ын дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалд, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг [www. Edoc.ub.gov.mn](http://www.Edoc.ub.gov.mn) домэйн нэр бүхий онлайн Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг ашиглан ажиллаж байна. 2017 оны 12 сарын 31-ний байдлаар 136 албан бичиг хүлээн авч, 152 албан бичиг явуулсан ба нийт бичиг хэргийн эргэлт 288 байна.

“Мөнгөн хөрөнгийн нөөцийн зохистой ашиглах” хүрээнд:

Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу мөнгөн хөрөнгийг зарцуулсан. Санхүүгийн тайлан бүртгэл нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн гаргаж баталгаажуулав.

2017 оны 2-р сард Нийслэлийн Аудитын газраас Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд манай байгууллагын 2016 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон санхүүгийн тайланд аудит хийж, тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан бүх үйл ажиллагаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7-д заасны дагуу анхан шатны баримтад үндэслэгдсэн болно.

“Бует хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах” хүрээнд:

Бараа материалын тооллогыг долоо хоног бүр хийж, хариуцсан нярав, тооцооны нягтлан бодогчтой тулгаж, сар бүр агуулахын үлдэгдлийг баталгаажуулан ажиллаж байна. Түгээлтийн тээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалтад анхаарч, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоолын дагуу тээврийн хэрэгслийн техникийн хяналтын ээлжит үзлэгт, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт хамруулан, тухай бүр засвар үйлчилгээ хийж, явсан зам, шатахууны зарцуулалтыг тооцон жолооч нарт хяналт тавьж, тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байна.

“Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:

Ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхээр Magic choice сургалтын төвд борлуулалтын нярав Б.Од-Эрдэнэ 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл няравын сургалтад амжилттай хамрагдаж №17UB1 01/57 дугаарт сертификаттай, Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн найруулга зүй сургалтад хамрагдан суралцаж, сертификаттай төгсөв.



Монгол эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Дэлхийн Монгол эмэгтэйчүүдийн хоёрдугаар чуулган 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 3 дугаар сарын 05-ны өдрийн хооронд АНУ-ын Чикаго хотод “Монгол орны хөгжлийн гарцыг хамтдаа

гаргацгаая” зорилгын дор зохион байгуулагдаж, түүнд эрүүл ахуйч их эмч М. Ичинхорлоо оролцов.




Монгол эмэгтэйчүүдийн хоёрдугаар чуулганд Монгол оронд тулгамдаж буй асуудлаар Герман, Солонгос, АНУ-д ажиллаж амьдарч байгаа эрдэмтэн Монгол эмэгтэйчүүдийн илтгэл тавигдлаа. "Хорт хавдрын эс дэх хавдар дарангуйлагч уураг" сэдвээр илтгэгч Д.Нүрмаагийн болон "Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудлууд" Т.Алдарсайханы илтгэлүүд олны анхаарал татаж байлаа.

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс Хууль тогтоомжийн тухай, төрийн албаны болон хөдөлмөрийн харилцаа, гэрээний эрх зүйн чиглэлээр 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Нийслэлийн Хангарди ордонд зохион байгуулагдсан сургалтад Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан А.Мөнхболор хамрагдав.



03 дугаар сард нярав Б.Баттуяа, борлуулалтын нярав Б.Азаяа нарыг Дүүжин өргүүрийн операторчны сургалтад хамруулан, “Дүүжин өргүүрийн операторчин”-ны мэргэжлийн үнэмлэх олгуулан өргүүрийн техникийн ашиглалтын заавар, аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөн ажиллуулж байна.





04 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтэс, Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс, “Асгат” ОНӨААТҮГ-аар хамтран Нийслэлийн төрийн өмчит сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хоол, хүнсийг ханган нийлүүлдэг “Асгат”, “Хүнс-Хангамж төв”, “Багачууд хүнс”, “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын захирал, менежер, эрүүл ахуйч, технологич нарт танхимын сургалтыг явууллаа.

Сургалтад нийт 20 ажилтан, удирдлагууд хамрагдсан бөгөөд Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Эрүүл ахуйн тухай хуулиудад зааснаар хүнсний сүлжээнд оролцогч нь сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдах нөхцөл илэрсэн тохиолдолд түүнийг буцаах, татан авах, тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх, мөн эрүүл ахуйн зохистой дадал, сургууль цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний илчлэг түүнд тавигдах шаардлагын талаар сургалт хийж, зөвлөгөө өглөө.

Сургалтад оролцогчдоос асуулт, хариулт авч санал солилцсон бөгөөд сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хоол, хүнсийг ханган нийлүүлж байгаа газруудад тавигдах стандартыг боловсруулах, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг тулгамдаж буй асуудлаар санал дэвшүүлж, сургалтад хамрагдсан эрүүл ахуйч, технологич нарт НМХГ-ын даргын батламж гардууллаа.





Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх журам”-ын танилцуулга, онол арга зүйн сургалт 2017 оны 05 дугаар сарын 31-н өдөр “Хангарди ордон”-ны хуралдааны их танхимд зохион байгуулагдлаа. Дээрх сургалтанд байгууллагын Менежер Э.Сондаръяа хамрагдан, “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний чадавхыг бэхжүүлэх нь” сэдвээр сертификат авлаа.





Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан П.Хандсүрэн нь 2017 оны 08 дугаар сарын 21-2017 оны 09 дүгээр сарын 08-ны хооронд Монголын хүний нөөцийн Институтийн Хүний нөөцийн менежментийн мэргэшүүлэх үндсэн сургалтад хамрагдаж 2017 оны 17/064 дугаарт сертификаттай төгслөө.



Үндсэн үйл ажиллагааны талаар:



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 40 дүгээр захирамжаар 2011 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн “Хүнс-Хангамж төв” ОНӨААТҮГ нь байгууллагын дүрэм, бүтэц орон тоог батлуулан үйл ажиллагаа явуулж

байсан бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын дүрмийг шинэчлэн батлах тухай” 27 дугаар тогтоолыг үндэслэн, 2015 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/323 дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн батлуулан, Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны “Авто тав” ХК-ийн эзэмшлийн байранд оффисын байрыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулж, цэцэрлэгүүдээс өгсөн захиалгын дагуу хүнсний хангалтыг хэвийн хангаж байгаа

бөгөөд харилцагч цэцэрлэг, сургууль, эмнэлэг болон байгууллагуудаас улирал тутамд санал хүсэлт авч ажиллаж байна.

СХД-ийн төрийн өмчит 45 цэцэрлэг, Нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны 74, 121-р сургуулийн дотуур байр, Хүн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу захиалгат хүнсний бүтээгдэхүүнийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэн тендерийн үнэлгээний хорооны 2016 оны 12 сарын 02-ны өдрийн хурлын дүгнэлтийг үндэслэн "Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах", 2017-Б/001 дугаар бүхий тендер шалгаруулалтад тэнцсэн "Баатарууд тэнгэр" ХХК, "Хулагу Холдинг" ХХК-удтай хонины мах бэлтгэн нийлүүлэх гэрээ, 2017 оны 02 сарын 02 ны өдрийн хурлын дүгнэлтийг үндэслэн 2017-Б/002 дугаар бүхий тендер шалгаруулалтад тэнцсэн

- Жаврай-Үр ХХК Багц 02-02 Хүнсний ногооны багц
- Домог-Интернэшнл ХХК Багц 02-10 Хуурай сүүний багц
- Томбат ХХК Багц 02-11 Баруун бүсийн жигнэмэг багц
- Талх чихэр ХК Багц 02-15 Зүүн бүсийн талх нарийн боов багц
- Эко-Эрдэнэ ХХК Багц 02-20 Жимсний чанамал, шүүсний багц

багцуудад гэрээ байгуулан, бусад багцуудад 20 гаруй байгууллагатай шууд худалдан авах гэрээ байгуулж, 120 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авч, түгээн ажиллалаа. Зориулалтын автомашин, бүтээгдэхүүн хүлээн авах, хадгалах агуулахтай бөгөөд ажилтан бүр ажлын онцлогтоо тохирсон 3 ээлжийн ажлын хувцастай хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан, зургаан сар тутамд албан хаагчдыг Эрүүл мэндийн сайдын 212 дугаарт тушаалын дагуу 11 ажиллагсдыг 3 сарын 31-ний өдөр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, 09 сарын 11-ний өдөр давтан хамруулж ажиллав.

Байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд болон техникийн аюулгүй ажиллагаанд хийх хяналтын хүрээнд:

Машин техникийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг долоо хоног тутам шалгаж, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийлгэн, 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоолын дагуу 1 дүгээр сард 5245 УБУ улсын дугаарт Бонго тээврийн хэрэгслийн техникийн хяналтын ээлжит

үзлэгт, 2-р сард 7892 УБН дугаарт Mitsubishi Canter, 5 дугаар сард 2485 УБХ Mitsubishi Fuso, 2940 УБП Nissan Caravan, 5245 УБУ Kia Bongo тээврийн хэрэгслүүдийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт хамруулан, тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдлыг хангуулан ажиллалаа.

Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага, авто тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм, журам зэргийг мөрдлөг болгож, түгээлтийн авто машинуудын /7892 УБН, 2485 УБХ, 5245 УБП, 2940УБП/ 2017 оны эхний хагас жилийн Ачааны авто машины ЕС зөвшөөрлүүдийг авч, жолооч нарт хүлээлгэн өгөв.

Хүнсний бүтээгдэхүүнийг шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэхийн тулд машины чингэлгийн цэвэрлэгээг долоо хоногт 2 удаа, байгууллагын гадна орчны их цэвэрлэгээг баасан гарагуудад тогтмол хийж хэвшсэн. Ахуйн хортон шавж устгалын чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2017 оны 03 сарын 31-нд “Цэвэр орчин ариусгал” ХХК-тай байгуулан, хүнсний агуулахад улиралд нэг удаа халдваргүйжүүлэлтийн үйлчилгээг хийж акт үйлдэн ажиллаж байна.

Үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарт тавих хяналт шалгалтаар:

2017 онд Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит 45 цэцэрлэг, СХД-ийн эмнэлэг, Жаргалант тосгоны Хүн эмнэлэг, сургуультай бүтээгдэхүүн худалдах гэрээ, төрийн болон хувийн хэвшлийн нийт 30 гаруй байгууллага, иргэнтэй 160 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна.

Монгол улсын Шадар сайдын 2014 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тушаалын дагуу Хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах их эрсдэлтэй импортын хүнсний бүтээгдэхүүнийг Улсын байцаагчийн дүгнэлттэй татан авч, биет үзлэгийн шалгалт хийн, хадгалалтын горимыг баримтлан нийлүүлж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүн, талх, нарийн боов зэрэг түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг захиалгын дагуу үйлдвэрээс нь шууд /итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнг хавсарган/ түгээн ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, “Мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ыг үндэслэн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт, дагалдах санхүүгийн баримтыг хавсарган эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг захиалгын

дагуу бэлтгэн нийлүүлж байна. Захиалгыг 2016 оноос эхлэн цахим хаягаар авч ажиллаж байна. ҮХАА-н сайдын 2013 оны А/98 тоот тушаалын дагуу “Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох” бүртгэлийн хуудас, “Урагш нэг шат” болон “Хойш нэг шат” бүртгэлийн дэвтрийг хөтөлж ажилдаа хэрэгжүүлж байна. МХЕГ-ын даргын 2014 оны 156 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийн дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан, Бичил цаг уур, Эрүүл мэнд ариун цэврийн, Мэргэжлийн сургалт, Хөргөх төхөөрөмжүүдийн “хэмийн”, Лабораторийн сорилтын дүнгийн, Их цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэлийн, Хортон шавж устгалын, Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний, Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах үйл ажиллагааг бүртгэх, мэдээлэх, Татан авсан хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн талаарх мэдээлэл зэрэг бүртгэлүүдийг хөтөлж ажилдаа хэрэгжүүлж эхлээд байна. Долоо хоног бүр дотоод хяналт шалгалтын ажилтан нь хийсэн хяналт шалгалтын бүртгэл хөтөлж, өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн /хууль, дүрэм, журам, стандарт гэх мэт/ мэдээллийн сан бүрдүүлэн, хяналт шалгалтын ажлын үр дүн, авсан арга хэмжээний талаар илэрсэн зөрчил, дутагдлыг хэлэлцүүлэн шийдвэрлэж ажиллаж байна.

Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналтын хүрээнд:

Ажилчдыг түгээлтэд гарах бүрд хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар эрүүл ахуйч эмч зааварчилгаа өгөн ажилчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг ханган, ажлын зориулалтын хувцас хэрэгслээр болон түгээлтийн зориулалттай автомашин, хэмжих хэрэгслийн цэвэрлэгээ, эрүүл ахуйн шаардлагыг хангуулан ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүнтэй шууд харилцагч борлуулалтын нярав, жолооч, ачигч нар 3 ээлжийн ажлын хувцастай. Долоо хоног бүрийн Даваа гарагт хүнсний ногоо, Мягмар гарагт мах, Лхагва гарагт хуурай бүтээгдэхүүн, Пүрэв, Баасан гарагуудад нэмэлт бүтээгдэхүүний түгээлт хийж байна.

Байгууллагын ажлын байранд тавигдах эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шаардлага хангуулах, хөдөлмөрийн болон дотоод хяналт шалгалтын журмыг шинэчлэн, хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажиллаж, “Хүнсний тухай хууль”, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль”-г судлуулж дагаж мөрдүүлэх талаар арга хэмжээ авч байна.

Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Нэг: Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй хууль, тогтоомжийн талаар:

Хүнсний бүтээгдэхүүн худалдан авах гэрээний дагуу харилцагч байгууллага, цэцэрлэгүүдтэй бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн болон худалдан авсан тооцоог сар бүр гарган, өглөг, авлагыг тодорхойлон тухай бүр тооцоо нийлэн, акт үйлдэж баталгаажуулан ажиллаж байна.

Тус газар нь аж ахуйн нэгжийн тайлан баланс гаргадаг бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд “Их монгол хөлөг” ХХК аудит хийсэн бөгөөд тус газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэлд тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн, зөв шударга илэрхийлэгдсэн гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлтийг 2017 оны 03-р сард гаргасан байна.

Байгууллагын өмч хамгаалах байнгын комиссыг шинээр байгуулж, бүтэн жилийн эд аж ахуйн тооллого хийж хүн нэг бүрээр карт хөтөлж, эд хөрөнгө тавилга тоног төхөөрөмжийг хариуцуулан бүртгэгдүүлсэн.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” 2012 оны 05 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.8 дахь хэсгийг үндэслэн “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт”-аар 2 албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын зөрчил болон хөрөнгө орлогын мэдүүлгийг дахин шинэчлэн авч хуулийн хугацаанд нь тайлагналаа. Улс, орон нутгийн төсөв, өмч, хөрөнгийг зөв зүйтэй зарцуулах, энэ чиглэлээр гаргаж байгаа шийдвэр, түүний хэрэгжилтийн ил тод байдлыг ханган ажиллаж, "Шилэн дансны тухай" хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж байна.

2017 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар журам, Аудитын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын үндсэн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын Төсвийн тухай хууль, “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”, “Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын

зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийслэлийн засаг дарга бөгөөд УБ хотын захирагчийн 2017 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийн 2017 оны зорилт, МУ-ын хууль тогтоомж болон засгийн газар, Нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн биелэлтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Санхүүгийн тайланг улирал бүр “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргаж Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтэст, Татварын тайланг улирал бүр гаргаж онлайнаар шивэн Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэст тус тус хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын тайланг сар бүр гаргаж, онлайнаар шивэн эх хувийг Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж, ажилчдын нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтрийг баталгаажуулан ажиллаж ААНОАТ, ХХОАТ-т 13,4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 25,9 сая төгрөг төлсөн.

Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан Шилэн дансны тухай хуулийг дотооддоо хэрэгжүүлэн байгууллагын цахим хуудсанд цаг тухайд шинэчлэл хийж ажиллав.

Байгууллагын 2018 оны бизнес төлөвлөгөөг боловсруулан, санхүү болон эдийн засгийн судалгаа хийж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг боловсруулан ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал:

Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан Шилэн дансны тухай хуулийг дотооддоо хэрэгжүүлэн байгууллагын цахим хуудсанд цаг тухайд шинэчлэл хийж ажиллав.

Монголын үндэсний статистикийн хорооноос гаргасан Улаанбаатар хотын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн харьцуулсан үнийн судалгааг авч,

бүтээгдэхүүний үнэтэй харьцуулах ба гэрээний дагуу харилцагч байгууллагаас үнийн өөрчлөлтийг албан бичгээр хүлээн авч, жишиг үнэ тогтоож, цэцэрлэгүүдэд бүтээгдэхүүн нийлүүлэх үнийг тогтворжуулахын тулд үнийн санал авч ажиллаж байна.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Нийслэлийн 2016 оны төсөв батлах тухай” 32-33 дугаар тогтоолоор агуулахын барилгын зардал болох 350 сая төгрөгийг батлуулан, 2016 оны төсөвт суулгаж, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт тендер шалгаруулалт зарлан “Содон-Номин констракшин” ХХК шалгарч, агуулахын барилгын ажлыг гүйцэтгэлээ.



2017 оны 05 дугаар сарын 27-ны өдөр БСШУСЯ-аас Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, ерөнхий боловсролын үйлчилгээ, сургалтын хөтөлбөр хэрэгжилтийн хүртээмж, чанар, үр ашгийг танилцуулах, боловсролын бодлого хэрэгжилтийн онцлог, ололт, амжилтыг сурталчилж иргэдэд зөвлөх үйлчилгээ зохион байгуулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг танилцуулах “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгууллаа.

Үйл ажиллагаанд тухайн байгууллагын албан хаагчид, багш нар, СӨБ-ийн хүнсний хангалтыг хариуцан ажилладаг байгууллагууд хамтран оролцож, “Үдийн цай” хөтөлбөр, сурах бичиг, сурагчийн дүрэмт хувцас, сургууль, цэцэрлэгийн барилга, боловсролын баримт бичгийн олголт, цэцэрлэгийн хүүхдийн хүнсний хангалт, эрүүл ахуйн шаардлага зэрэг үйл ажиллагаа зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд өөрийн байгууллагын Менежер Э.Сондаръяа, Хүний нөөц бичиг хэргийн ажилтан П.Хандсүрэн, Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь нар оролцож СӨБ-ын хүүхдийн хүнсний хангалт, бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдал, сувиллын болон өдрийн цэцэрлэгийн хүүхдийн нэг хоногийн хоолны илчлэг нормын талаар үзэсгэлэн гаргаж, үзүүлэх ажил зохион байгуулан, иргэдэд

үйлчилгээ үзүүлж, зөвлөх, сурталчилгааны материал тараан, өөрийн үйл ажиллагааг танилцуулан сурталчилж, эцэг эх болон нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон иргэдээс санал хүсэлт авч, зөвлөмж тараан ажиллалаа.



106-р цэцэрлэг “Эрүүл зөв хооллолт хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй” өдөрлөг

05 дугаар сарын 04-ны өдөр СХД-ийн 106 -р цэцэрлэг “Эрүүл зөв хооллолт хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй” өдөрлөгийг хамтран зохион байгуулан явуулав. Өдөрлөгийн арга хэмжээнд тус цэцэрлэгийн Эрхлэгч Н.Хоролмаа, “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын Захирал Б.Ичинхорол, Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь мөн тус цэцэрлэгийн эцэг эхчүүд оролцсон.

Нээлтийн үйл ажиллагаа



Бүтээгдэхүүний танилцуулга



226-р цэцэрлэг “Хоолны өдөрлөг”

05 дугаар сарын 23-ны өдөр СХД-ийн 226 –дугаар цэцэрлэг “Хоолны өдөрлөг” хамтран зохион байгуулан явуулав. Өдөрлөгийн арга хэмжээнд тус цэцэрлэгийн эмч, арга зүйч багш ажилчид, мөн “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын Ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь мөн тус цэцэрлэгийн эцэг эхчүүд оролцсон.

Нээлтийн үйл ажиллагаа



Бүтээгдэхүүний танилцуулга



113 дугаар цэцэрлэг хоолны өдөрлөг

113 дугаар цэцэрлэг нь 2017.11.23 өдөр " Эрүүл хүнс- Зөв хооллолт" сэдэвт өдөрлөгийг эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгт "Хүнс хангамж" төвийн ахлах нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, хүнсний мэргэжилтэн Оюундарь, ЭМН-ийн 14 төвийн хүний нөөцийн дарга Зулцэцэг нар хүрэлцэн ирж эцэг эхчүүдтэй санал бодлоо солилцлоо.



226 дугаар цэцэрлэгийн хоолны өдөрлөг

226 дугаар цэцэрлэг нь 2017.11.23 өдөр Хоолны амталгаат өдөрлөгийг эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгт "Хүнс хангамж" төвийн ахлах нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, хүнсний мэргэжилтэн Оюундарь нар хүрэлцэн ирж эцэг эхчүүдтэй санал бодлоо солилцлоо.



99 дүгээр цэцэрлэгийн хоолны өдөрлөг

99 дүгээр цэцэрлэг нь 2017.11.23 өдөр “Таны хүүхдийн зоог” өдөрлөгийг эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгт "Хүнс хангамж" төвийн ахлах нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, хүнсний мэргэжилтэн Оюундарь нар оролцлоо.



2017 оны эхний хагас жилийн байдлаар лабораторийн сорилтын дүнг цахимаар хүргүүлэн ажиллалаа.

д/д	Цэцэрлэгийн дугаар	Захиалга өгсөн хүний албан тушаал	Захиалга өгсөн хүний нэр	шуудан-р өгсөн	Утсаар өгсөн
1	41 цэцэрлэг	Нярав	Б.Энхтуяа	blq_568@yahoo.com	99790569
2	55 цэцэрлэг	Нярав	М.Отгонтуяа	otgoo_922@yahoo.com	89670444
3	79 цэцэрлэг	Нярав	Т.Отгонжаргал	t.otgonjargal_0813@yahoo.com	89447070
4	90 цэцэрлэг	Нярав	Д.Ичинхорлоо	ichinhorloo9990@yahoo.com	96009990
5	99 цэцэрлэг	Нярав	Р.Ундрал-Эрдэнэ	undral80@yahoo.com	99001360
6	101 цэцэрлэг	Нярав	Х.Болормаа	booghii_kh@yahoo.com	99017578
7	104 цэцэрлэг	Нярав	В.Эрдэнэчимэг	bayartuya163@yahoo.com	91810171
8	105 цэцэрлэг	Нярав	Д.Мөнхцэцэг	muugii_bj@yahoo.com	99173764
9	106 цэцэрлэг	Нярав	Д.Цэцэгмаа	rose_erdenee@yahoo.com	93130360
10	107 цэцэрлэг	Нярав	Д.Чулуунбат	otgoo_107@yahoo.com	99273000
11	110 цэцэрлэг	Нярав	Д.Оюунтунгалаг	tungalag_1286@yahoo.com	89153322
12	112 цэцэрлэг	Нярав	Ц.Найманжин	naimaa2636@yahoo.com	99262636
13	113 цэцэрлэг	Нярав	Б.Түмэнжаргал	baljka_113@yahoo.com	99183614
14	118 цэцэрлэг	Нярав	П.Байгаль	ariun09@yahoo.com	88409096
15	119 цэцэрлэг	Нярав	Я.Өлзийбаяр	ulzii119@yahoo.com	99833494
16	125 цэцэрлэг	Нярав	А.Долгорсүрэн	doogiinoo_smile@yahoo.com	95940869
17	26 цэцэрлэг	Нярав	Ж.Ургамал	-	97151439
18	48 цэцэрлэг	Нярав	Эрдэнэчимэг	altaacendnyam@yahoo.com	93224114
19	80 цэцэрлэг	Нярав	Б.Энхжаргал	jargalb81@yahoo.com	91165241

20	81 цэцэрлэг	Нярав	С.Баярцэцэг	-	88957692
21	92 цэцэрлэг	Нярав	Т.Ганчимэг		70181260
22	111 цэцэрлэг	Нярав	Х.Саранчимэг		96656278
23	148 цэцэрлэг	Нярав	М.Пүрэвжаргал	m_pvvjee1210@yahoo.com	99921210
24	156 цэцэрлэг	Нярав	Х.Алтанзул	zulaa09_19@yahoo.com	93120103
25	176 цэцэрлэг	Нярав	Б.Хоролмаа	altaa_188@yahoo.com	98705548
26	188 цэцэрлэг	Нярав	С.Алтанцэцэг	-	89739554
27	226 цэцэрлэг	Нярав			
28	СХДНЭ	Нярав	Н.Нэргүй	nergvi9660@gmail.com	96660763
29	38 цэцэрлэг	Нярав	О.Алимаа		93211080
30	78 цэцэрлэг	Нярав	П.Дэнсмаа	bayanaa_1127@yahoo.com	
31	84 цэцэрлэг	Нярав	Б.Байгалмаа	baigalmaa0301@yahoo.com	98186692
32	91 цэцэрлэг	Нярав	н.Одончимэг	odnoo_2625@yahoo.com	91113497
33	117 цэцэрлэг	Нярав	Ш.Байгалмаа	nandia_4612@yahoo.com	
34	127 цэцэрлэг	Нярав	Ш.Нямсүрэн	argazuich127@yahoo.com	98641212
35	158 цэцэрлэг	Нярав	О.Нямдорж	oyunaa_3336@yahoo.com	98983003
36	163 цэцэрлэг	Нярав	М.Цэцэгмаа	ltseegii_tseegii@yahoo.com	96095459
37	170 цэцэрлэг	Нярав	Ч.Одончимэг	odnoo_chd@yahoo.com	
38	192 цэцэрлэг	Нярав	Л.Даваасүрэн	l.davaa1970@yahoo.com	99073164
39	214 цэцэрлэг	Нярав			
40	215 цэцэрлэг	Нярав			
41	227 цэцэрлэг	Нярав	Мөнхзул		99202933
42	74 сургууль	Нярав	Л.Гантулга	enkhamgalan1964@	88955570
43	121 сургууль	Нярав			
44	116цэцэрлэг	Нярав	Бямбаа	uyanga_nyamdo@yahoo.com	96695311
45	ЖТХЭ	Нярав	Нансалмаа	sb_badmaa@yahoo.com	88600146
46	195цэцэрлэг	Нярав	Б.Гэрэлтуяа	pp_nyamka@yahoo.com	99217564
47	196цэцэрлэг	Нярав	И.Шинэцэцэг	shinetsetseg0901@yahoo.com	96044453

2016 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийн ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

“Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар”, “АПУ ТРЕЙДИНГ” ХК-тай хамтарсан сургалт

2017-2018 оны хичээлийн жилд "Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-аас сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын нярвуудад "Хүүхдийн хоол хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, хадгалалт хамгаалалт" сэдэвт ээлжит сургалтаа АПУ трейдинг ХК-тай хамтран амжилттай зохион байгууллаа. Тус сургалтад Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын ахлах байцаагч Н.Одончимэг "Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх аргачлал", "Агуулахын стандарт, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт" сэдвээр, "Хүнс хангамж төв"

ОНӨААТҮГ-ын хүнсний технологич Г. Оюундарь " Хүнсний бүтээгдэхүүний цахим захиалга өгөх зөвлөмж" сэдвээр, АПУ трейдинг ХК-ийн мастерууд "Сүү, сүүн бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалт" сэдвээр тус тус сургалт явуулж сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн явцтай танилцлаа. Сургалтад оролцсон нярвуудад Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, "Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын хамтарсан "БАТЛАМЖ" гардууллаа.





Сонгинохайрхан дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсээс зохион байгуулсан сургалт

Сонгинохайрхан дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсээс хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдад хэрэглэгдэж буй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал нь барилга, байгууламж, гадна орчинд тавих нөхцөл, усан хангамж, хог хаягдлыг зөв менежмент хийх, хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг шалгаж, хүлээн авах, зөв хадгалах, хоол хүнсийг болгож боловсруулах, хөргөх, хадгалах, дахин халаах, дамжин бохирдохоос урьдчилан сэргийлэх, угаалга цэвэрлэгээг хийх арга, дотоод хяналтыг тавих зэрэг цогц асуудлаар сургалт хийж дараах зөвлөмжийг өглөө..

1. Барилга байгууламж

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах барилга, байгууламж болон гадна орчноос хамаарах хоол үйлдвэрлэлд ноцтой хор хохирол гарах эрсдэл өндөр байна. Үүнд:

- Байгууламжийн гадна талбай нь сул шороогүй, урд хойд хаалгаар орох гарах хэсэгт явган хүний зам нь хатуу хучилттай байх

- Хог тарж орчныг бохирдуулахаас сэргийлж, битүүмжлэлтэй хогийн цэгтэй, хогоо тогтмол зайлуулдаг, цэвэрлэдэг байх
- Хоол үйлдвэрлэлийн өрөөний бүхий л хэсэгт бохир агаарыг соруулахад хүрэлцэхүйц хүчин чадалтай агааржуулалт суурилуулж, үйл ажиллагааг хэвийн эсэхийг тогтмол шалгадаг байх
- Цонхонд суурилсан сэнс, торон хаалттай байх
- Хоол үйлдвэрлэлийн өрөөний тааз, хана, шалыг цайвар өнгөтэй ус, чийгт тэсвэртэй, угааж цэвэрлэхэд тохиромжтой материалаар хийсэн байх
- Шал нь халтиргаа үүсгэхээргүй материалаар өнгөлөгдсөн ус бохирдол хуримтлагдах ан цав, нүхгүй жигд байх
- Тааз, хана, шалны залгаас, уулзвар булан зай завсаргүй байх

Барилга, байгууламжийн хана, тааз, шал, цонхны бүрэн бүтэн байдалд тодорхой хугацаанд хяналт тавьж, засвар үйлчилгээ, тогтмол чанартай хийж, үйл ажиллагаанд саад түвэг учруулахгүйгээр цэгцтэй байлгах нь зүйтэй.

2. Дамжин бохирдол

Дамжин бохирдол нь хоол хүнсний хордлогыг үүсгэх хамгийн түгээмэл шалтгааны нэг юм. Энэ нь хөнөөлтэй бактериуд хоол хүнс, багаж хэрэгслээр дамжин хүнсэнд тархдаг. Эдгээр бактери нь ихэвчлэн түүхий мах, шувууны мах, өндгөнд агуулагддаг. Хор хөнөөлтэй бактерийн эх үүсвэр нь ажиллагсад, хортон шавж, хоолны хэрэгсэл, алчуур байдаг.

3. Хувийн эрүүл ахуй

- Хүнсэнд хор хөнөөлтэй бактери тархахаас сэргийлэхийн тулд ажиллагсад хувийн эрүүл ахуйн сайн дадлуудыг дагаж мөрдөх нь чухал юм.
- Бүх ажилчид хоол хүнстэй харьцаж ажиллах үедээ ажлын цэвэрхэн хувцас өмсөх ёстой
- Ажиллагсад нэн ялангуяа түүхий мах, шувууны мах, өндөгтэй ажиллахдаа заавал цэвэрхэн хормогчийг ажлын хувцасны гадуур өмсөж байх
- Хоол хүнстэй харьцах үедээ юм ууж, идэх, бохь зажлах, тамхи татаж болохгүй. Мөн өөрийн нүүр, хамарт хүрэх, ханиах, найтаахаас зайлсхийх
- Эрүүл мэндийн үзлэгт 6 сар тутамд орж байх
- Суулгах, бөөлжих шинж тэмдэг илэрсэн үед ажилтан дээрх шинж тэмдгээ арилснаас хойш 48 цагийн дараа ажилдаа эргэн ирэх

- Ажилчдын хувцас солих өрөөтэй байна. Цүнх гадуур өмсдөг хувцас, торыг хоол хүнс бэлтгэх газарт байрлуулахгүй байх
- Нэг удаагийн бээлийг хэрэглэж байх

Алчуур

- Алчуур нь гал тогоонд дамжин бохирдол үүсгэх гол эх сурвалж учир бичил биетэн тархахаас сэргийлж алчуурыг зөв хэрэглэж, аюулгүй байдлыг хангаж байх
- Боломжтой бол нэг удаагийн алчуур хэрэглэж, бохирдсон тохиолдол бүрт хаяж байх
- Идэхэд бэлэн хоол хүнстэй харьцах, ажлын гадаргуу, хоолны хэрэгсэл, сав суулгыг шинэ алчуураар арчих, эсвэл дөнгөж цэвэрлэсэн алчуур хэрэглэх
- Олон дахин хэрэглэдэг алчуурыг арчиж цэвэрлэсэн бол сайтар угааж байх
- Алчуурыг халуун усаар сайтар угааж, халдваргүйжүүлэх хэрэгтэй

Хүнсний хадгалалт

Хүлээн авах

- Түүхий эд хүлээн авах цагийг төлөвлөж байх
- Түүхий мах, шувууны мах, өндгийг бусад хүнснээс өөр цагт хүлээн авах нь зүйтэй.
- Хүнсний түүхий эдийг цэвэрхэн, тусгай газарт хүлээн авах
- Гадна баглаа боодлыг салгаж хаяхдаа хольцын мэдээллийг тэмдэглэж авна. Учир нь зарим шошго зөвхөн гадна тал дээрээ бичээстэй байдаг.
- Түүхий эд, идэхэд бэлэн хүнсийг тусад нь хадгална. Хэрэв нэг хөргөгчид хадгалж байгаа бол түүхий мах, шувууны махыг идэхэд бэлэн хүнсний доод тавиурт хадгална. Болгож боловсруулсан болон бусад идэхэд бэлэн хүнсийг битүү бүтээж таглана.

Гэсгээлт

- Зөв зохистой гэсгээгээгүй хүнсэнд хор хөнөөлтэй бактери үржих магадлалтай.

- Болгож боловсруулахын өмнө хүнсийг сайтар гэсгээх хэрэгтэй. / Үйлдвэрлэгчийн заавар дээр хөлдүү чигээр нь болгож боловсруулна гэж заасан, эсвэл танд баталгаатай аюулгүй арга байгаагаас бусад тохиолдолд/

Хүнсийг гэсгээхдээ:

- Хөргөгчид:
- Хамгийн найдвартай арга боловч хэдэн цагаас өдөр зарцуулагдах болно. Том хэмжээтэй бүтээгдэхүүнийг гэсгээхэд олон өдөр зарцуулагдана. Иймд гэсгээхэд хангалттай хугацаа, зайг урьдаас төлөвлөх хэрэгтэй.
- Урсгал хүйтэн усанд:
- Хэрэв хүнсийг хөргөгчид гэсгээх боломжгүй бол хүнсийг тагтай саванд хийгээд хүйтэн урсгал усанд тавина. Цэвэрхэн угаалтуур ашиглаж ундны усны урсгал усаар гэсгээх бүтээгдэхүүнийг эргүүлж тойруулж хурдан гэсгээнэ.
- Богино долгионы зууханд:
Зуухны гэсгээх тохиргоонд хүнсийг гэсгээж болно. Энэ нь овор багатай хүнсийг богино хугацаанд гэсгээж хэрэглэнэ.
Манай байгууллагаас эрүүл ахуйч их эмч М.Ичинхорлоо, хүнсний технологич Г.Оюундарь, борлуулалтын нярав П.Равдансамбуу, М.Нацагдорж, Б.Од-Эрдэнэ нар оролцлоо.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан сургалтууд

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсээс "Эрүүл мэнд боловсролын хяналтад иргэн таны оролцоо" сарын аяны хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүнсний хангамж хариуцсан Хүнс хангамж төв ОНӨААТҮГ, Багачууд хүнс ОНӨААТҮГ, Өсвөр Үе хүнс ОНӨААТҮГ, Асгат ОНӨААТҮГ-ын захирал, эрүүл ахуйч эмч, дотоод ажилтан нарт үзүүлэх сургалтыг амжилттай зохион байгууллаа



“Багшийн сэтгэл зүй - Ажлын ачаалал” сэдэвт салбарын сургалт

Нийслэлийн сургуулийн өмнөх сургалтын байгууллагын удирдлагуудад "Багшийн сэтгэл зүй-Ажлын ачаалал" сэдэвт салбарын сургалтыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтэс, дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагчид, Монгол их сургуулийн Сэтгэл судлалын танхимын багш нар хамтран 2017 оны 10 сарын 06-ны өдөр Олон улсын Найрамдал төвд амжилттай зохион байгуулж явууллаа.

Тус сургалтаар Боловсролын шинэчлэлийн сэтгэл зүйн зарим асуудал, цэцэрлэгийн багшийн ажлын үнэлгээ, хамт олны сэтгэл зүй, судалгаа, оношилгооны энгийн аргуудыг эзэмшүүлэх, багшийг ажлын байранд нь хөгжүүлэх, үнэлэх, дүгнэх, боловсролын стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, ахиц, үр дүнг хэрхэн тооцох, боловсролын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчлүүд, дотоод хяналтыг зохион байгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн 217 цэцэрлэгийн эрхлэгч нар хамрагдав.



Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын Үндэсний чуулган

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Хүнсчидийн холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын Үндэсний чуулганыг 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулав.

Чуулганд Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын захирал Б.Ичинхорол, менежер Б.Мягмарсүрэн, хүнсний технологич Г.Оюундарь нар хамрагдав.

Энэхүү чуулганаар Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангахад хууль эрхзүйн орчин, дотоодын үйлдвэрлэлийг сайжруулах, хүнсний хяналт, хэрэглэгчдийн хүнсний тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар зөвлөмж гаргасан.



Цэцэрлэг сургуулийн ажилтнуудад сургалт зохион байгуулах тухай

Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Нийслэлийн боловсролын газар, сургуулийн өмнөх боловсролын хүнсний хангамжийг хариуцан ажилладаг Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ, Асгат ОНӨААТҮГ, Хүнс хангамж төв ОНӨААТҮГ, Багачууд хүнс ОНӨААТҮГ, Шинжлэх Ухаан технологийн их сургууль, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран цэцэрлэгийн тогооч, ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн орон тооны бус хяналтын зөвлөлийн дарга, ахлагч, тогооч нарт хоол шим тэжээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хоол үйлдвэрлэл үйлчилгээнд зохистой дадлыг нэвтрүүлэх, дэвшилтэт технологийг хүүхдийн хоолны үйлдвэрлэлд нэвтрүүлэх талаарх ойлголт олгож нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгийн 227 тогооч, нийслэлийн төрийн өмчийн сургуулийн эцэг эхийн зөвлөл, тогооч нарын 241 хүнийг хамрууллаа.

СХД-ийн төрийн өмчит цэцэрлэгийн ахлах тогооч нарт зориулсан сургалт

СХД-ийн төрийн өмчит цэцэрлэгийн ахлах тогооч нарт зориулсан сургалт 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн амралт, спорт цогцолборт амжилттай болж өндөрлөө.

Сургалтад нийт 43 цэцэрлэгийн ахлах тогооч нар хамрагдаж урилгаар Шинжлэх Ухаан технологийн Их сургуулийн Хоол үйлдвэрлэл, шим судлалын тэнхимийн эрхлэгч, эрдэмтэн доктор, профессор, багш М.Пүрэвжав багш оролцож “Хүүхдийн хоолны цэс, орцын цэс боловсруулах, хянах аргачлал” сэдвээр сонирхолтой сургалт явууллаа.



ОНӨААТҮГ-ын дунд зохион байгуулсан спорт наадам

05 дугаар сарын 20-ны өдөр Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийг хариуцан ажилладаг “Асгат”ОНӨААТҮГ, “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ, “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ, “Багачууд хүнс” ОНӨААТҮГ газар, тэдгээрийн ажилтан, албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, шилдэг баг тамирчдыг шалгаруулах зорилготой уламжлалт тэмцээн зохион байгуулагдав.

Уг тэмцээн Ус сувгийн удирдах газрын спорт зааланд зохион байгуулагдаж, өөрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж,

- Эрэгтэй сагсан бөмбөг – Мөнгөн медаль
- Даартс /холимог баг/ - Мөнгөн медаль
- НӨХГазрын эмэгтэй багтай хангамжийн 4 байгууллагын шилдэг тоглогчдоос бүрдсэн эмэгтэй баг бооцоот тоглолт хийн, амжилт гарган оролцлоо.



“Dawa Cup” нэрэмжит олон улсын өртөөт марафон

“DAWA” цомын нэрэмжит “Үзэсгэлэнт Улаанбаатар-2017” олон улсын өртөөт марафон Улаанбаатар хотноо 08 дугаар сарын 13-ны өдөр боллоо. Энэхүү анхдугаар тэмцээнийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир,

спортын газар, нийслэлийн биеийн тамир, спортын хороо, “Grand china sport” холбоо хамтран зохион байгуулж “Жуулчин”, “Гэр бүл”, “Найзууд”, “Сэтгэлд хоногшсон Улаанбаатар” гэсэн ангиллаар зохион байгуулагдсан юм. “Найзууд” ангилалд “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын борлуулалтын нярав П.Равдансамбуу, үйлчлэгч Б.Алтангэрэл нар оролцож таван өртөөг дамжин өгөгдсөн даалгавруудыг хугацаандаа амжилттай гүйцэтгэлээ.



Санхүү, эдийн засгийн алба үүсэн байгуулагдсаны 106 жилийн ой

Санхүү, эдийн засгийн алба үүсэн байгуулагдсаны 106 жилийн ой, Нийслэлийн санхүү бүртгэлийн ажилтнуудын баярын цэнгүүнд Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын нягтлан, нярвууд оролцлоо. 106 жилийн ойг угтсан урлагийн наадамд Хүнс хангамж төвийн оролцсон "Актив" баг тэргүүлж шилдгийн шилдгээр шалгарч шилжин явах цом, өргөмжлөлөөр шагнууллаа.

"Актив" багийн хамт олон



“Хүнс-Хангамж төв” ОНӨААТҮГ-ын Дотоод хяналт шалгалтын журмын дагуу СХД-ийн гэрээт цэцэрлэгүүдийн гал тогоо, хүнсний агуулахын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдалд цаашид авах арга хэмжээний тухай зөвлөмж

Манай байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын дагуу хүнсний бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээт байгууллага СХД-ийн шинээр ашиглалтад орсон 26, 214, 215, 226-р цэцэрлэгүүд, өргөтгөл хийгдсэн 41,80,170-р цэцэрлэгүүд, 55, 80, 81, 84, 111, 125, 127, 158, 176, 188, 26, 156-р цэцэрлэгүүдийн гэр цэцэрлэгийн гал тогоо, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, аюулгүй байдалтай танилцаад тэмдэглэх нь:

СХД-ийн шинээр ашиглалтад орсон 26-р цэцэрлэг үндсэн байрандаа 260, гэр цэцэрлэгт 60 хүүхэд, 214, 215, 226-р цэцэрлэгүүд 120 хүүхдийн чадалтай баригдсан боловч 250-260 хүүхэдтэй, хүнсний бүтээгдэхүүн, ногоо хадгалах агуулахтай, өргөтгөл хийгдсэн 41-р цэцэрлэг 120 хүүхэд, 80-р цэцэрлэг 40 хүүхэд, 170-р цэцэрлэг 380 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөл хийгдсэн, 80-р цэцэрлэгээс бусад өргөтгөл хийгдсэн цэцэрлэгүүд хүнсний бүтээгдэхүүн, ногоо хадгалах агуулахтай байна. СХД-ийн нийт 12 цэцэрлэгт 28 бүлэг, 55 гэрт 781 хүүхэд хамрагдаж байна.

Цэцэрлэгийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалтай танилцах үед илэрсэн зөрчил дутагдлууд:

1. 55, 80, 81, 84, 111, 125, 127, 158, 176, 188, 26, 156-р цэцэрлэгүүдийн гэр цэцэрлэгүүд хүүхдийг зөөврөөр хооллодог, ахуй хангамж, хооллох, гар угаах, бие засах нь нэг гэрт явагддаг, усан хангамж зөөврийн зэрэг дутагдлууд илэрч байна.

2. 81, 158, 176, 188, 26-р цэцэрлэгүүдийн гэр цэцэрлэгүүд зуух тавьж түлээ нүүрс түлж байгаа нь агаарын бохирдлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

3. Гэр цэцэрлэгүүдэд усан хангамж дутагдалтай, аяга таваг, хоолны хэрэгслийг 3 саванд ус хийж угааж байгаа нь хоолны хэрэгсэл угааж халдваргүйтгэх заавар зөрчигдөж, гэдэсний халдвартай, халдварын бус өвчин дамжих тархах нөхцөлийг бүрдүүлж байна.

4. 158-р цэцэрлэг 1 гэрт гал тогоо ажиллуулж 120 хүүхдийн хоол ундааг 2 зууханд гал түлж хийж байгаа нь хоолны технологи, хүнсний бүтээгдэхүүн хадгалах эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангагдахгүй, хөргөгч, хөлдөөгч дутагдалтай байна

5. Хүнсний бүтээгдэхүүн, мах, ногоог төрөлжүүлэн хадгалаагүй, агуулах хүрэлцээгүй, агуулах болон гал тогоонд харьцангуй чийг, хэм хэмжигч 41-р өргөтгөл, шинээр баригдсан 215-р цэцэрлэгийн хүнсний агуулахад тавигдаагүй байна.

6. Болсон түүхий бүтээгдэхүүний тавиур, махны мод, хутга хэрэгсэлд таних тэмдэг тавигдаагүй, тусгаарлагдаагүй, дамжин бохирдуулах нөхцөл бүрдүүлсэн

7. 170-р цэцэрлэг эмчгүй учир хүүхэд хүлээн авахдаа эрүүл мэндийн үзлэг хийдэггүй

Авсан арга хэмжээ, мэргэжлийн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө өгсөн байдал:

СХД-ийн шинээр ашиглалтад орсон 26, 214, 215, 226-р цэцэрлэгүүд, өргөтгөл хийгдсэн 41, 80, 170-р цэцэрлэгүүд, 55, 80, 81, 84, 111, 125, 127, 158, 176, 188, 26, 156-р цэцэрлэгүүдийн гэр цэцэрлэгүүдийн тогооч, нярав, багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цэцэрлэгүүдийн гал тогоо, хүнсний агуулах, бүтээгдэхүүний хадгалалтын байдалд судалгаа хийж ажиллав.

Дээрх зөрчил дутагдлыг үндэслэн хүнсний бүтээгдэхүүн хүлээн авч, хадгалах горим, чанар, аюулгүй байдлын шаардлага хангуулж, хүнсээр дамжих халдвартай болон халдварын бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Хүнсний бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, стандартад заасан хэмд хадгалах горимыг баримталж, агуулахад харьцангуй чийг, хэм хэмжигч тавьж өдөр тутам бүртгэл хөтөлж хяналт тогтоож, бүтээгдэхүүний чанарыг муудгахаас сэргийлэх

2. Болсон түүхий бүтээгдэхүүний тавиур, махны мод, хутга хэрэгсэлд таних тэмдэг тавьж, тусгаарлан, зориулалтын дагуу ашиглан бүтээгдэхүүнийг дамжих бохирдохоос сэргийлэх

3. Гал тогоонд хүнсний бүтээгдэхүүн хийж буй сав суулганд мэргэжлийн

хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулж, хүнсний бүтээгдэхүүний зориулалттай сав, суулга, аяга, таваг хэрэглүүлэх

4. Хүнс, хоол түгээх сав суулгыг угааж, цэвэрлэх, халдваргүйтгэх зааврыг баримтлан, сав, суулгаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллуулах

5. Хүнсний бүтээгдэхүүнтэй шууд харьцагч ажилчдыг ажлын хувцас халат болон гар угааж халдваргүйтгэх нөхцөлөөр хангаж, түүнд дотоод хяналт шалгалтын ажилтан байнгын хяналт тогтоож, хэвшүүлэх талаар онцгой анхаарч ажиллах зөвлөмж өгөв.

6. Гэр цэцэрлэгүүдийн халаалт, ахуй хангамж, хүүхдийн хооллолт, гэр гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмжид одоогийн мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн хоол, хүнстэй холбоотой хордлого, хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах нь зүйтэй байна.

Гэрээт цэцэрлэгүүдийн гэр цэцэрлэг, гал тогоо, хүнсний агуулах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, аюулгүй байдалтай танилцаж, судалгаа авч үнэлэлт, дүгнэлт гаргаж, зөвлөмж, зөвлөгөөг “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлтэд дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авах арга хэмжээний тухай” 2017 оны 2 сарын 10 өдрийн 34 тоотор СХД-ийн Боловсролын хэлтсийн дарга А.Дүүдээд хүргүүлэв.

2017 оны сэтгэл ханамжийн судалгаа

2017 оны эхний хагас жилийн сэтгэл ханамжийн судалгаанд СХД-ийн төрийн өмчит цэцэрлэгүүд, 74 дүгээр сургууль, Жаргалант тосгоны Хүн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг зэрэг нийт 43 байгууллагын ахлах тогооч, эрхлэгч нар хамрагдаж, үйлчилгээний талаарх санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгааг авч үнэлэлт дүгнэлт өгч ажиллаа.

1. Бүтээгдэхүүний /мах, хүнсний ногоо, хуурай бүтээгдэхүүн/ чанар талаарх хэрэглэгчийн санал хүсэлт, гомдол, нэмэлт үйлчилгээ

Нийт 43 байгууллагын ахлах тогооч нар хамрагдсанаас 53.4% буюу 23 цэцэрлэгээс санал хүсэлт, гомдлын мөр гарсан байна. Үүнд:

- Хонь, үхрийн махны талаарх судалгаанд 9 цэцэрлэгээс
- Хүнсний ногоо талаарх судалгаанд 14 цэцэрлэгээс

- Хуурай бүтээгдэхүүн талаарх судалгаанд 3 цэцэрлэгээс тус тус санал ирсэн байна.

2. “Хүнс-Хангамж төв” ОНӨААТҮГ-ын хүргэж буй үйлчилгээний талаар

Судалгаанд хамрагдсан ахлах тогооч нар 93% саналаар ажилчдын харилцаа хандлага сайн, үйлчилгээ сайтай, түргэн шуурхай захиалсан бараа бүтээгдэхүүнийг түргэн шуурхай цаг хугацаандаа нийлүүлж, сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна. Мөн манай хамт олонд ажлын амжилт хүссэн байна.


3. Санал гомдлын мөрөөр авсан арга хэмжээнүүд

Дээрх судалгаагаар ирсэн санал гомдлын мөрөөр холбогдох гэрээт байгууллагуудтай холбогдон хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр нийлүүлэх, чанарын шаардлага нийцээгүй бүтээгдэхүүнийг буцаан авч, чанартай бүтээгдэхүүнээр сольж, гомдлыг барагдууллаа. Хүнсний ногоо бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай холбогдон төмс, лууванг дахин ялгуулж, сортлуулан, хаягдлыг багасгуулан түгээлтэд гаргалаа.

Шпагетти гоймонгийн нэр төрлийг нэмэгдүүлэн макарон гоймонг цэцэрлэгүүдийн захиалгын дагуу түгээн ажиллалаа.

Цайны жигнэмгийн судалгааг хийж, нэр төрлийг олшруулах, шинэ бүтээгдэхүүний талаар цэцэрлэгүүдэд танилцуулах ажлыг Хүнсний мэргэжилтэнд үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Санал хүргүүлсэн цэцэрлэгүүдтэй холбогдон ахуйн бараа болон хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, захиалга өгсөн өдрийн он сарыг зөв тодорхой бичих, захиалгын хуудсан дээр тодорхой бичиж байхыг мэдэгдэв.



Эрхлэгч нарын үүлзалт

2017-2018 оны хичээлийн жилд СХД-ийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч нарыг хүлээн авч уулзаж цэцэрлэгийн гэрээгээ шинэчлэн хийж энэ жилээс сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүнийг үйлдвэрээс нь шууд нийлүүлж гурвалсан гэрээ хийн ажиллаж байна. Үүнд:

- Талх чихэр ХК
- Атар өргөө ХК
- Сүү ХК
- Мон сүү ХК
- АПУ трейдинг ХК



Бидний бүтээлч ажил

Өмнө нь



Дараа нь





Байгууллагын ойр орчмын шарилж, лууль, хөл газрын ургамлыг устгах ажлыг зохион байгууллаа.

2017.08.13

“Намрын бүх нийтийн цэвэрлэгээ”

Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны 2017.10.12-ны өдрийн 01/2145 тоот албан бичгийн дагуу “Намрын бүх нийтийн цэвэрлэгээ”-нд байгууллагын нийт ажилчдыг хамруулж имартын уулзвараас дарь эхийн уулзвар хүртэлх замыг цэвэрлэж нийслэлийн шуурхай удирдлага зохицуулалтын төвд мэдээлж ажиллаа.

“Мод тарих үндэсний өдөр”

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай ” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны намрын бүх нийтээр мод тарих өдрийг 10 дугаар сарын 14-нд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГазартай хамтран тус хүрээлэнд чацарганын бут суулгаж модонд усалгаа хийж, тогоог цэвэрлэн, хөл газрын ургамлыг устгах ажилд оролцлоо.



Дүгнэлт

“Хүнс-Хангамж төв” ОНӨААТҮГ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендер

зарлаж шалгарсан аж ахуйн нэгж байгууллагуудаас чанарын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүн хүлээн авч Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдийг чанартай хүнсний бүтээгдэхүүнээр захиалгын дагуу тухай бүрд нь санал гомдолгүй ханган нийлүүлж, тайлангийн хугацаанд гадаад дотоодын сургалтад холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулж, төлөвшүүлж мэргэшүүлснээр ажлын бүтээмж дээшилж Сонгинохайрхан дүүргийн сургуулийн өмнөх байгууллагад хоол хүнсээр дамжин халдварлах хоолны хордлого, хордлогот халдвар гаргаагүй, аюулгүй байдлыг хангуулж амжилттай ажиллаа.

Цэцэрлэгт нийлүүлж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын талаар сургалт өдөрлөг зохион байгуулан цэцэрлэгийн эрхлэгч нярав, тогооч, багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхийн зөвлөлүүдэд танилцуулан, санал хүсэлт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийж үнэлэлт дүгнэлт гаргаж, зөв зохистой хооллох дадал хэвшилд сургах арга зүйн мэдлэг өгснөөр хүнсний бүтээгдэхүүн хүлээн авахад тавигдах шаардлага, нярвын үйл ажиллагаа, хоолны технологи, цэсийн төлөвлөлт сайжирч хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон хоол хүнсээр хангах үйл ажиллагааг явуулж ирсэн.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан нийт 43 цэцэрлэгээс 27 цэцэрлэг буюу 53,4% нь бүтээгдэхүүний чанар болон үйлчилгээний талаар санал ирүүлсэн. 40 цэцэрлэг буюу 93% саналаар манай байгууллагаас хүргэж буй үйлчилгээнд сэтгэл хангалуун, үйлчилгээ сайтай, түргэн шуурхай, бүтээгдэхүүний чанар сайн, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хангадаг, түгээлтийн ажилчдын харилцааны соёл сайн, сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна. Цэцэрлэгүүдийн ахлах тогооч нарын өгсөн санал хүсэлтийг цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан үзүүлэлт гарч байгаа нь хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон хоол хүнсээр хангаж ажилласныг харуулж байна.

Байгууллагын ололт амжилтыг бататган, хүнсний хангамжийн бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг улам сайжруулах, соёлтой бөгөөд түргэн шуурхай үйлчилж цаашид хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

